



ДУЛААНЫ Ш ЦАХИЛГААН СТАНЦ
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН
ТУШААЛ

2017 оны 04 сарын 25 өдөр

Дугаар Б/143

Улаанбаатар хот

Хөдөлмөрийн гэрээг ажил олгогчийн
санаачилгаар цуцлах, ажил хүлээлцэх
комисс томилох тухай

Монгол улсын Хөдөлмөрийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1.2, 40 дүгээр зүйлийн 40.1.3 дахь заалт, Компанийн захиргаа, түүний дэргэдэх Үйлдвэрчний эвлэлийн хорооны хооронд байгуулсан 2015-2017 онд хэрэгжүүлэх Хамтын гэрээний 5.13 дахь заалт, Компанийн хөдөлмөрийн дотоод журмын 7.3.6 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. 60 нас хүрч өндөр насны тэтгэвэр тогтоолгох эрх нь үүссэн Авто аж ахуйн хэсгийн жолооч Билдхан овогтой Расольтой байгуулсан хөдөлмөрийн гэрээг 2017 оны 04 дүгээр сарын 25-ны өдрөөс эхлэн ажил олгогчийн санаачилгаар цуцалж үүрэгт ажлаас нь чөлөөлсүгэй.

2. Эрчим хүчний салбарт 34 жил ажилласан Б.Расольд 26112000 төгрөгийн нэг удаагийн тэтгэмж олгосугай.

3. Б.Расолийн ажлыг хүлээж авах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай. Үүнд:

<u>Комиссын дарга:</u>	Д.Баянжаргал	Аж ахуйн эрхэлсэн дэд захирал
<u>Гишүүд:</u>	Б.Нарансолонго	Санхүү бүртгэлийн хэлтсийн үндсэн хөрөнгийн нябо
	А.Лхагважав	Авто аж ахуйн хэсгийн Автын инженер, механик
	Б.Жүгдэрнамжил	Авто аж ахуйн хэсгийн Үйлчилгээний жолооч

4. Ажлыг 2017 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр жолооч Б.Жүгдэрнамжилд хүлээлцүүлж холбогдох баримт бичиг бүрдүүлэхийг /Комиссын гишүүд/-д даалгасугай.

5. Б.Расольтой цалин хөлс, ээлжийн амралт, эд аж ахуйн тооцоо хийж дуусган нэг удаагийн тэтгэмжид зарцуулагдах 26112000 (хорин зургаан сая нэг зуун арван хоёр мянган) төгрөгийг ажилтны нийгмийн зардлаас олгохыг Санхүү бүртгэлийн хэлтсийн дарга /Л.Доржхорлоо/-д үүрэг болгосугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Г.ДАМДИНСҮРЭН

